



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/313

Зуунмод

Хадлан, гар тэжээл бэлтгэх
тухай

Зуунмод суманд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хүрээнд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт аймгийн Засаг даргын 2023 оны А/584 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нөөц болон малчин, мал бүхий иргэдийн 2023 онд бэлтгэх хадлан, гар тэжээлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Сумын Хөдөө аж ахуйн тасаг /Б.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1.Сумын нөөцөд болон малчин, мал бүхий иргэдийн 2023 онд бэлтгэх хадлан, гар тэжээлийг хавсралтад заасны дагуу 9-11 дүгээр сард багтаан бэлтгэн нөөцлүүлж, мэдээг тухай бүрт нь мэргэжлийн байгууллагад хүргүүлж ажиллах.

2.2.Хадлан, гар тэжээл бэлтгэх болон цаг үеийн ажлын зохион байгуулалтыг бүрэн дүүрэн хангаж, байнга хяналт тавин сумын удирдлагуудыг мэдээ мэдээллээр тогтмол ханган, шаардлагатай асуудлыг тухай бүр нь шийдвэрлүүлж ажиллах.

3.Багийн Засаг дарга, зохион байгуулагч нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

3.1.Баг байгууллага, малчин, мал бүхий иргэдийг 2023 онд бэлтгэх хадлан, гар тэжээлийн төлөвлөгөөг малчин, мал бүхий өрх, байгууллага аж ахуйн нэгж тус бүрт өгч төлөвлөгөөг биелүүлэн, ажлыг өөрсдийн хүч хөрөнгөөр 9-11 дүгээр сард багтаан хэрэгжүүлэх.

3.2.Багийн хэмжээнд малчин, мал бүхий өрх бүрээр төрөл бүрийн гар тэжээл бэлтгүүлж, нөөцлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах.

3.3.Хувиараа өөр аймаг сумын нутагт өвс, хадлан бэлтгэх хүсэлтэй иргэдийн санал санаачлагыг дэмжин судалгааг гаргаж хамтран ажиллах.

3.4.Хадлан гар тэжээл бэлтгэлийн явцад байнгын хяналт тавьж ажил эрчимжүүлэн, явцын мэдээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр сумын ХАА-н тасагт ирүүлж байх.

3.3.Хадлан тэжээл бэлтгэлийн эцсийн мэдээ тайланг 11 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэх.


4.Байгалийн бэрхшээлийг хохирол багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлэн, мал аж ахуйн өвөлжилт хаваржилтыг эртнээс ханган, даалгаварт өвс тэжээлийг бүрэн бэлтгэж нөөцлөхийг нийт малчид, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ





Сумын Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 14-ны өдрийн 313 дугаар
захирамжийн хавсралт

ХАДЛАН ГАР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Багийн нэр	Малын тоо						Сумын нөөцөнд			Мал бүхий иргэд байгууллагын бэлтгэх өвс /тн/	Тэжээл /тн/		
		Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Өвс /тн/	Гар тэжээл /тн/	Гар тэжээл /тн/		Үйлдвэрийн тэжээл /тн/	Ногоон тэжээл /тн/	
1	Номт	12272	3	2386	987	5979	2917	10.0	8.0	314.0	305.0	33.3	33.3	
2	Ланс	13549	0	1458	1042	6321	4728	10.0	8.0	315.6	306.0	34.0	34.0	
3	Баянхошуу	12643	0	1190	871	5773	4809	10.0	8.0	314.5	305.0	33.3	33.3	
4	Зүүндэлгэр	25644	3	3831	1541	12307	7962	10.0	9.0	400.0	310.0	36.0	36.0	
5	Нацагдорж	12470	4	1455	895	6337	3779	10.0	8.0	314.5	305.0	33.3	33.3	
6	Баруунзуунмод	19081	0	2417	1303	9587	5774	10.0	9.0	380.0	308.0	34.0	34.0	
	Нийт	95659	10	12737	6639	46304	29969	60.0	50.0	2038.6	1839.0	203.9	203.9	

ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР